



ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ ТАРХАЛТЫН ХОЁР ДОЛОО ХОНОГ ТУТМЫН МЭДЭЭ №6

Нэг. Монгол оронд бүртгэгдсэн шувууны томуугийн сэжигтэй тохиолдол

2025 оны 05 дугаар сарын 01 - нээс 06 дугаар сарын 01 - ний хооронд шувууны томуугийн холбогдолтой өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй.

Өвчний сэжигтэй шувууд таарсан тохиолдолд ЗӨСҮТ-ийн **70282853** дугаар эсвэл дараах холбоосоор мэдээлэл илгээнэ үү. <https://arcg.is/KXDjy>

Хоёр. Дэлхий дахинд бүртгэгдсэн шувууны томуугийн хүний өвчлөл

2025 оны 05 дугаар сарын 01 - нээс 06 дугаар сарын 01 - ний хооронд шувууны томуугийн холбогдолтой өвчлөлийн сэжигтэй 2 тохиолдол бүртгэгдсэн.

Тохиолдол 1:

Камбожи улсын Кампонспы мужид 11 настай хүү өндөр хоруу чанартай шувууны томуугийн H5N1 хэвшинжээр өвдөж, 2025 оны 05 дугаар сарын 28 нд нас барсан. Тархвар судлалын холбогдлоор хүүхдийн гэрийн ойролцоо 7 хоногийн өмнөөс бөднө, тахиа, нугас зэрэг шувууд өвчилж байсан. Он гарсанаас хойш олон улсад шувууны томуу өвчнөөр нас барсан 4 дэх тохиолдол болж байна.

Тохиолдол 2:

БНХАУ-ын Гуанши мужид Вьетнам улсаас ирсэн 53 настай, эмэгтэй өндөр хоруу чанартай шувууны томуугийн H5N1 хэвшинжээр өвдсөн.

Гурав. Дэлхий дахинд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусээр өвчилсөн амьтдын мэдээлэл:

2025 оны 05 дугаар сарын 01 - нээс 06 дугаар сарын 01 - ний хооронд шувууны томуугийн А хүрээний вирус АНУ, Бангладеш, Бразил, Болгар, Камбожи, Канад, БНХАУ, Чех, Дани, Грек, Ирланд, Герман, Итали, Япон, Латви, Дани, Молдав, Нигери, Польш, Филиппин, БНСУ, Швед, Унгар, Их Британи зэрэг 21 улс орны газар нутагт нүүдлийн болон тэжээвэр шувуудын дунд 95 тохиолдол бүртгэгдсэн. (Хүснэгт 1, зураг 1)

Хүснэгт 1. Шувууны томуугийн А хүрээний вирусийн хэв шинжээр тархалт


Дэд хэвшинж	Улс	Зүйлийн нэр	Нийт тохиолдол
H5N1	АНУ	Шувууны аж ахуй, үхрийн ферм	18
H5	Бангладеш	Хүний өвчлөл	1
H5	Белги	Хүрэн толгойт цахлай, гунгар хун	3
H5N1	Бразил	Хун	3
H5N1	Болгар	Тахианы аж ахуй	1
H5N1	Камбожи	Тахианы аж ахуй	1
H5N1	Канад	Тахианы аж ахуй, муур, хэрээ, илбэнх	11
H5N1	Чех	Тахиа, нугасны аж ахуй, гунгар хун	1
H5N1	Дани	Шилийн сар	1
H5N1	Герман	Тахианы аж ахуй, тодорхойгүй	2
H5N1	Грек	Шувууны аж ахуй, тодорхойгүй	1
H5N1	Ирланд	Эгэл хараалай	1
H5N1, H5	Япон	Хэрээ	3
H5N1	Нигери	Шувууны аж ахуй	1
H5N1	Недерланд	Галуу, цахлай, шар шувуу	9
H5N1	Польш	Шувууны аж ахуй	6
H5N1	Филиппин	Шувууны аж ахуй	3
H5N1	БНСУ	Хөх дэглий, тураг гогой	5
H5N1	Испани	Бор галуу	2
H5N1, H5N5	Швед	Цагаан сүүлт нөмрөг бүргэд	5
H5N1, H10N3	БНХАУ	Хүний өвчлөл	2
H5N1	Унгар	Шувууны аж ахуй, тодорхойгүй	5
H5N1	Их Британи	Шувууны аж ахуй, саарал галуу	16
H5N1	Норвеги	Хонь	1

Эх сурвалж: <https://empres-i.apps.fao.org/>

Ихэвчлэн Америк тивийн улс оронд үхрийн ферм, шувууны аж ахуйд, Европ, Зүүн Азийн улс оронд усны шувууд болох хун, галуу, нугасны төрлийн шувуудаас өвчлөл бүртгэгдсэн.

Өнгөрсөн 14 сарын хугацаанд өндөр хоруу чанартай шувууны томуугийн H5N1 хэвшинжээр АНУ-д үхэр, Пакистан улсад хонь, ямаа, Монголд адуу, Норвеги, Их Британи улсад хонь өвчилсөн байна.

Зураг 1. 2025 оны 05 дугаар сарын 01 нээс 06 дугаар сарын 01 ний хооронд шувуудын дунд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусийн тохиолдлын тархалт



НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД, ТАНДАЛТ ШУУРХАЙ УДИРДЛАГЫН АЛБА